



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/559

Номгон

Шүлхий өвчөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг яаралтай зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а”, 29.1.6 “а, л” заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 25-ны дотор шуурхай зохион байгуулж, дүн мэдээг долоо хоног тутам аймгийн Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т мэдээлж байхыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Дархлаажуулалтын ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, дүн мэдээг удирдах ажилтны шуурхай хуралдаанд танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, яаралтай дархлаажуулалтын ажилд мал сүргээ бүрэн хамруулж шаардлагатай хашаа, хороо хүн хүчээр хангаж ажиллахыг нийт малчдад үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Хишигбаатар)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210299